



Шинжээчийн тайлан

Байгууллагын нэр: Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн Магистр, докторын сургууль

Сургалтын хөтөлбөрийн нэр: “Байгаль орчны хяналт, үнэлгээ” магистрын зэрэг олгох хөтөлбөр

Индекс: E07120104

Шинжээчийн баг:

Ахлагч: Ц.Дэлгэрсайхан /МУБИС-ийн Багшийн сургуулийн захирал/

Гишүүд: З.Баттогтох /ШУТИС-ийн ЭХС-ийн дэд профессор /

Д.Сэржмядаг /ОБЕГ-ын дэргэдэх Гамшиг судлалын Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга/

Он сар өдөр: 2019.03.19

Агуулга

Хуудас

Товчилсон үгийн тайлбар	4
I. Магадлан шинжлэх үйл явц, төлөвлөлт	5
II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга.....	6
III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт	7
Шалгуур1: Хөтөлбөрийн төлөвлөлт.....	7
Шалгуур 2: Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл.....	9
Шалгуур 3: Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт.....	13
Шалгуур 4: Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа.....	19
Шалгуур 5: Багшийн үйл ажиллагаа.....	24
Шалгуур 6: Сургалтын үйл ажиллагаа.....	28
Шалгуур 7: Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө.....	32
Шалгуур 8: Чанарын үнэлгээ, баталгаажилт.....	36
IV. Оролцогчдын нэрс.....	39
I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.....	39
II. Оюутны нэр.....	40
III. Ажил олгогч.....	40
IV. Төгсөгчид.....	41
V. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал.....	42
ҮI. Мэргэжлийн зөвлөлийн шийдвэр	43
ҮII. Магадлан итгэмжлэх комиссын шийдвэр	44

Товчилсон үгийн тайлбар

ААН – Аж ахуй нэгж
АЭС – Агроэкологийн сургууль
БЗД – Баянзүрх дүүрэг
БЦГ – Байгалийн цогцолборт газар
БОХТ - Байгаль орчныг хамгаалах технологи
БОХУ- Байгаль орчны хяналт, үнэлгээ
БОНС – Байгаль орчны нөхөн сэргээлт
БОНУ – Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ
БОНХАЖЯ – Байгаль Орчин Ногоон Хөгжил Аялал Жуулчлалын Яам
БОАЖЯ-Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОНБУ-Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
БСШУСЯ – Боловсрол Соёл Шинжлэх Ухаан Спортын Яам
ГБ - Гэрээт багш
МҮОНРТ – Монглын Үндэсний Олон Нийтийн Радио Телевиз
МУИС – Монгол Улсын Их Сургууль
МУБИС-Монгол улсын багшийн их сургууль
МДС- Магистр докторын сургууль
МХГ- Мэргэжлийн хяналтын газар
ОБЕГ- Онцгой байдлын ерөнхий газар
ШУА – Шинжлэх Ухааны Академи
ШУТИС-Шинжлэх ухаан технологийн их сургууль
ХБЦГ – Хустайн Байгалийн Цогцолборт Газар
УНБУ – Ургамлын нөөц биоүйлдвэрлэл
УНМ – Усны нөөцийн менежмент
УМС – Удирдлагийн мэдээллийн систем
ҮБ – Үндсэн багш
ТББ – Төрийн бус байгууллага
ХААИС – Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ХК – Хувьцаат компани
ХХК-Хязгаарлагдмал хариуцлагатай компани

II. Сургалтын хөтөлбөрийн танилцуулга

Хөтөлбөрийн нэр: Байгаль орчны хяналт, үнэлгээ

Хөтөлбөрийг шууд харъяалах удирдлагын нэгж: ХААИС, Магистр, Докторын сургууль

Сургалтын хэлбэр: Өдөр, зайн

Суралцах хугацаа: 1.5-2 жил

Хөтөлбөрийн индекс: E07120104

Олгох боловсролын зэрэг: Магистр

Элсэгчдийн боловсрол: Байгаль орчны, хууль эрх зүйн, технологийн чиглэлийн бакалавр

Хөтөлбөрийг хариуцах нэгж: Байгаль орчны хяналт, үнэлгээний хөтөлбөрийн хороо

Хөтөлбөр анх боловсруулж, сургалт явуулах эрх авсан огноо: /04/ 2008

Хөтөлбөрийг анх баталсан огноо: 2009 оны 7-р сард

Хөтөлбөр хамгийн сүүлд шинэчлэгдсэн огноо: 2017 оны 8-р сарын 20

2008 оноос эхлэн 115 оюутан элсэж, одоогоор 54 магистр БОХУ хөтөлбөрөөр хамгаалсан. 100% ажлын байртай. Экологийн тэнхимийн 16 доктороос гадна ХААИС-ийн бусад тэнхмээс 6 багш хичээл заадаг.

III. Шинжээчийн үнэлгээ, дүгнэлт

Шалгуур 1. Хөтөлбөрийн төлөвлөлт

Оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэсэн, үйл ажиллагааны төлөвлөлт, зохицуулалтын цогц баримт бичгийг нийтлэг шаардлагын дагуу иж бүрэн боловсруулан баталгаажуулж, тогтмол сайжруулдаг байна.

1.1. Хөтөлбөрийн хэрэгцээ, шаардлага

Хөтөлбөр нь үндэсний болон олон улсын боловсролын чиг хандлагыг баримжаалан, сургалтад оролцогч болон сонирхогч талуудын хэрэгцээг хангахад чиглэн боловсруулагдсан байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Нийгэм, эдийн засаг, технологи, салбарын хөгжлийн ирээдүйн төлөв, сонирхогч талуудын эрэлт хэрэгцээнд дүн шинжилгээ хийсэн байдал
- Төгсөгчийн /мэргэжилтний/ загвар
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн гадаад дотоодын хөтөлбөрүүдтэй харьцуулсан байдал /ялгаатай, давуу, сул тал, сайжруулалт/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Монгол улсын байгалийн нөөцийн ашиглалт, хамгаалалтад хяналт хийх байгууллагуудын эрэлт хэрэгцээнд тулгуурлан сургалтын стандарт хөтөлбөр нь боловсруулагдсан.
- ХААИС 2006 оноос эхлэн БОХҮ хөтөлбөрөөр монголдоо анх удаа мэргэжилтэн бэлтгэж эхэлсэн.
- Хөтөлбөрийн эрэлт хэрэгцээний STEEP шинжилгээ хийжээ.
- БОХҮ хөтөлбөрийн төгсөгчийн загварыг гаргахдаа оролцогч талуудын эрэлт хэрэгцээ, суралцахуйн онол, байгаль шинжлэлийн болон инженер технологийн шинжлэх ухааны онол, үзэл баримтлалд тулгуурлан хандлага, ур чадвар, мэдлэг, чадамж 4 гэсэн чиглэлээр тодорхойлжээ.
- Байгаль орчны үнэлгээ хийдэг мэргэжлийн байгууллагуудын ажлын шаардлагад нийцүүлэн төгсөгчийн загвараа боловсруулсан.
- Төгсөгчийн загварт 2012, 2012-2016 оноор харьцуулсан судалгаа хийж, дүгнэлт хийжээ.
- Хөтөлбөрийг индексийн хувьд ижил салбар, чиглэлийн тухайд МУИС-ийн Экологи, байгаль орчны хяналт үнэлгээ, ШУТИС-ийн Үйлдвэрийн экологи, МУБИС-ийн Экологийн магистрын хөтөлбөрүүдтэй сургалтын төлөвлөгөөний бүтцийн харьцуулалт хийсэн байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн агуулгын шинэчлэлийг олон орны ижил мэргэжлийн хөтөлбөрүүдтэй харьцуулан сайжруулж, энэ хөтөлбөрөөр төгсөгч нь Монгол улсдаа төдийгүй олон улсад гарч ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэхээр төлөвлөж байгаа боловч гадаадын их, дээд сургуулийн ижил төстэй мэргэжлийн хөтөлбөртэй харьцуулсан судалгааг тайланд тусгаагүй байна.
- Сургалтын хөтөлбөрт инженерчлэлийн болон технологийн чиглэлийн хичээлүүд багатай байна.

Зөвлөмж:

- БОХУ хөтөлбөрт магистрын түвшинд шаардагдах математик болон физик загварчлал, системийн анализ хийх, бохирдуулагч эх үүсвэрийн технологи үйл ажиллагааг судлах мэдлэг, ур чадварыг олгохын тулд инженерийн чиглэлийн хичээлүүдийг оруулж өгөх нь зүйтэй.

1.2 Хөтөлбөрийн үзэл баримтлал, зорилго

Хөтөлбөрийн үзэл баримтлал тодорхой; төгсөгчийн эзэмшсэн байх мэдлэг, ур чадвар, хандлага нь мэргэжлийн салбарын хөгжил, зах зээлийн эрэлтэд нийцсэн байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримталж байгаа үзэл баримтлал, сургалтын арга зүй, тогтсон үнэлгээний систем
- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, онцлог, сургуулийн эрхэм зорилго, зорилттой нийцсэн байдал
- Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход оролцогч, сонирхогч талуудын саналыг тусгаж, хөтөлбөр боловсруулах ажлын хэсэгт төлөөллийг оролцуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл /Туршлага:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн, зорилго ХААИС болон МДС-ийн эрхэм зорилготой нийцсэн байна.
- Хүрээлэн буй орчны гэмт хэрэг, байгаль орчны зөрчлийг шалган шийдвэрлэх үйл ажиллагаа хийдэг МХГ, Цагдаагийн газарт ажиллах ажлын байрны шаардлагыг хангах чадамжийг олгохыг хөтөлбөр зорилгоо болгодог.
- Хөтөлбөрийн сургалтын арга зүйд үр дүнд суурилсан сургалтын уламжлалт арга, “Case study”, асуудал дэвшүүлэн шийдвэрлэх арга, марафон бичлэг, “Raft” бичлэг, “KWL” бичлэг, эссэ бичлэг зэрэг орчин үеийн арга зүйг хэрэглэж байна.
- 2018 оноос эхлэн Е сургалтыг хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн.

- Сургалтын арга зүй, хэлбэр, үнэлгээний тогтолцооны өөрчлөлтийг 2014 оноос өмнө ба дараах байдлаар харьцуулан судалжээ.
- Багш нарын сургалтын арга зүйд SWOT шинжилгээ хийж түүний давуу болон сул талыг тодорхойлж, сайжруулах боломжийг авч үзсэн.
- Хөтөлбөрийн үр дүнд GAP шинжилгээ хийжээ.
- Хөтөлбөрийн төгсөгчид болон байгаль орчны салбарт ажиллаж байгаа мэргэжилтнүүдийг чадавхжуулахын тулд улсын хэмжээнд 1, орон нутгийн түвшинд 7 сургалтыг зохион байгуулсан байна.
- Төгсөгчдийг ажлын байраар хангах, онол практикийн мэдлэгийг холбох үүднээс Монгол улсын 21 аймгийн БОАЖ-ын газар, МХГ-ын байгаль орчны салбаруудтай хамтран ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн ерөнхий хороо болон дэд хороод тогтмол үйл ажиллагаа явуулдаггүй.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийн чанарын шинэчлэлд багш бүрийн оролцоог сайтар хангах, хөтөлбөрийн үзэл баримтлалыг багш бүр ойлгож, өөрийн заадаг хичээлийн агуулга, арга зүй, үнэлгээгээ сайжруулахад нь арга зүйн зөвлөмж, сургалтыг Хөтөлбөрийн хороод болон хөтөлбөрийн албадууд тогтмол сайн хийж, хэрэгжүүлж хэвших шаардлагатай байна.

1.3 Хөтөлбөрийн төлөвлөлтийн баримт бичгүүд

Сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр нь тухайн хөтөлбөрөөр суралцагчид олгох мэдлэг, ур чадвар, хандлагын агуулга; сургалтын үр дүнд чиглэсэн арга зүй; сургалтын үнэлгээний оновчтой хэлбэрийг бүрэн багтааж, оролцогч болон сонирхогч талуудын санал зөвлөмжийг тогтмол тусган сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрт тавигдах нийтлэг шаардлагыг хангаж, баталгаажуулсан байдал
 - Сургалтын төлөвлөлт нь онол, практикийг зохистой хослуулсан, суралцагчийн мэргэжлийн болон хувь хүний ур чадваруудыг хөгжүүлэхэд чиглэсэн байдал
- Хичээлийн хөтөлбөр нь хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, агуулга, ур чадварын хувьд харилцан залгамж холбоотой, сургалтын арга зүйн болон үнэлгээний олон талт арга, хэлбэрийг тусгасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл / Туршлага:

- 2017 оны 06 сарын 29-ний өдрийн А/52 БСШУ-ны сайдын тушаалаар Байгаль ашиглалт, хяналт, үнэлгээ гэсэн бие даасан хөтөлбөр баталснаар БОХУ хөтөлбөр БОХТ хөтөлбөрөөс бие даан хөгжих эрх зүйн үндэс тавигдсан.

- Оролцогч болон сонирхогч талуудын сэтгэл ханамжийн судалгааг байгаль орчны салбарын 12 байгууллагаас авахад төгсөгчид нь хамгаалсан чиглэл, мэргэжилдээ сайн, шинжлэх ухааны түвшин сайтай гэсэн дүгнэлтийг өгчээ.
- Хөтөлбөрөөр эзэмших мэдлэг, ур чадвар, хандлага, чадамжийн жагсаалтыг дэлгэрэнгүй гаргасан байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн дэд хороо ажилладаг гэх боловч хэлэлцэж, баталгаажуулсан баримт дутмаг байна.
- Сургалтын стандарт, хөтөлбөрт байгаль орчны хяналтын чиглэлийн агуулга ерөнхий байна.
- Өөр мэргэжлээс орж суралцаж буй суралцагсдад зориулсан зөвлөн туслах дадлагажуулах агуулгыг оруулах тал дээр анхаарч ажиллах.
- Байгаль орчны үнэлгээний чиглэлийг төрөлжүүлэх.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг шинэчлэхдээ холбогдох мэргэжлийн багш нар болон хөтөлбөрийн албаны мэргэжилтний мэдлэг, ур чадварыг тасралтгүй сайжруулах хэрэгтэй.
- Хөтөлбөрийн хичээлийн агуулгын уялдаа холбоог сайжруулж, төгсөгчдийн ажлын байрны шаардлагын гол чиглэл болох байгаль орчны хяналтын чиглэлийн хичээлийн сургалтын төлөвлөгөөнд эзлэх хувийг нэмэгдүүлэх нь зүйтэй.

1-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 2. Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл

Хөтөлбөрийн зорилго, зорилтыг үр дүнтэй хэрэгжүүлэх, амжилттай суралцахад дэмжлэг үзүүлэхүйц шаардлагатай нөөцийг бүрдүүлсэн эсэхэд дүгнэлт хийх

2.1 Сургалтын орчин

Сургалт, судалгаа явуулах анги танхим, лаборатори, урлан, багаж хэрэгсэл, багшийн ажиллах орчин нь хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх шаардлага хангасан, стандартад нийцсэн шинэчлэл хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Эрүүл, аюулгүй, тохилог орчинг бүрдүүлсэн байдал
- Тоног төхөөрөмж, мэдээллийн технологийн хэрэгсэл, лаборатори, урлангийн хангалт, ашиглалтын байдал
- Бие даан болон багаар ажиллах орчны хангалт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл / Туршлага

- Агроэкологийн сургууль нь ХААИС-ийн хичээлийн төв байрны баруун дээд жигүүрийн 1, 2, 3 давхарт байрлах бөгөөд 58 өрөө тасалгаатай, эдгээрээс багш нарын өрөө 22, лекцийн танхим 4, семинар дадлагын кабинет 12, лаборатори 17, бие даалтын танхим 2, эрдмийн зөвлөлийн өрөө 1 байна. Багшид ноогдох талбай 2013-2014 онд 4,15 м² байсан бол 2015-2017 онд 5,2м² болж нэмэгдсэн бол 1 оюутанд ноогдох талбайн хэмжээ 2011-2013 онуудад 0,59 м² - 0,49м² байсан бол 2014-2017 онуудад 0,6-0,7 м² болж нэмэгдсэн байна.
- ХААИС-ийн “Сургалтын бодлогын алба”-наас сургуулийн лаборатори, кабинетуудыг тодорхой шалгууруудаар аттестатчилдаг.
- Хичээлийн төв байранд утасгүй интернэтээр холбогдсон цахим банкны үйлчилгээтэй.
- Тус хөтөлбөрийн оюутнууд өөрөө өөртөө үйлчлэх хэвлэх машин байрлуулан ажиллаж байна.
- Хуучин 10 лабораторитой байсан бол эдгээрээс 4 нь шинэчлэн байгуулж, 7 лабораторийг шинээр байгуулжээ.
- Багш нарын өрөө, хичээлийн танхимууд интернэтийн сүлжээтэй. 2014 оноос сургуулийн интернэтийг сайжруулан хэрэглэж байсан Uniface программыг ULMS программаар шинэчилсэн.
- Зайсангийн ам, Төв аймгийн Борнуур, Баянчандмань, Батсүмбэр болон Говьсүмбэрт сургалт, судалгаа, үйлдвэрлэлийн төвүүдтэй. Тэндхийн томоохон үйлдвэр, аж ахуйн нэгжүүдэд дадлага хийдэг байна.
- Ахисан түвшний оюутнууд бие даан судалгаа, шинжилгээний ажил хийж гүйцэтгэх 3 өрөөтэй.

Анхаарах асуудал:

- БОХУ хөтөлбөрийн магистрын түвшний суралцагчдын сурч хөгжих, эрүүл аюулгүй тохилог орчинг бүрдүүлж чадаж байгаа эсэх талаар дүн шинжилгээ хийдэг байх
- Тайланд багшийн ажиллах орчны талаар мэдээлэл бүрхэг байна.

Зөвлөмж:

- Шалгуурын “эрүүл, аюулгүй тохилог орчинг бүрдүүлсэн байдал” гэдгийн дагуу үзүүлэлт нотолгоог сургалтын анги танхимын зай талбай нэмэгдсэн агуулгаар тайланд бичжээ. Энэ нь стандарт шаардлагыг хангаж байгаа эсэх талаар дүн шинжилгээ хийдэг байх нь чухал.

2.2 Сургалтын хэрэглэгдэхүүн

Хөтөлбөрийн онцлогоос хамааран зайлшгүй шаардлагатай сургалт, судалгааны программ хангамж, хичээлийн хэрэгсэл, материаллаг нөөцөөр хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Программ хангамж, симуляци, виртуал лабораторийн хэрэглээ, хүртээмж
- Хичээл практикийн материаллаг нөөц, хэвлэмэл үзүүлэн, тараах материал, хэрэглэгдэхүүний хүртээмж, хэрэглээ
- Сургалтын ажлыг зохион байгуулах заавар, удирдамж, зөвлөмжийн хүртээмж

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Газарзүйн мэдээллийн системийн тэргүүлэгч компани АНУ-ын ESRI компанийн хамгийн сүүлийн хувилбар ArcGIS pro программыг сургалтад хэрэглэж байна.
- Оюутнууд онлайн программ ашиглан, сургуулийн домайн хаягаар орж, өөрсдийн хийсэн бүтээлүүдээ тавих бөгөөд эдгээр нь веб сайтад харагдана.
- Сүүлийн 3 жилд Байгаль орчны хяналт, үнэлгээ, Байгаль орчны нөхөн сэргээлт мэргэжлийн хичээлүүдийн тараах материалуудыг онлайн болон бичлэг хэлбэрээр илүү нарийвчлан харуулах байдлаар үзүүлдэг болсон.
- 2013-2017 оны байдлаар хичээл сургалтад ашигласан шил сав, эм урвалжинд зарцуулсан мөнгөн дүн өсөлттэй гарсан байна.
- Лабораториудад магистрантуудад зориулсан ашиглалтын дэвтрийг байнга хөтлүүлж хэвшсэн.

Анхаарах асуудал:

- Албан ёсны лицензтэй программыг ашиглах боломжийг судлан хэрэгжүүлэхэд анхаарах. Энэ нь цаашид багш, судлаачид эрдэм шинжилгээний бүтээлүүдээ гадаадын чансаа өндөртэй сэтгүүлүүдэд хэвлүүлэхэд дөхөмтэй юм.

Зөвлөмж:

- Өнөөгийн сургалтад хэрэглэгдэж буй сургалтын хэрэглэгдэхүүн, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа, насжилтын байдалд дүн шинжилгээ хийж, түүнийг шинэчлэх талаар тодорхой арга хэмжээг авдаг байх нь зүйтэй. Тухайлбал, багш нарын компьютерын хүчин чадал нь ямар байгаа, цаашид ямар хүчин чадалтай компьютерээр шинэчлэх нь зүйтэй талаар судалгаа хийж, шийдвэрлүүлдэг байх.

2.3 Номын сан, мэдээллийн эх үүсвэр

Багш, суралцагчдын сургалтын үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхүйц хэрэгцээт мэдээллээр тогтмол, чанартай хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Үндсэн сурах бичиг, гарын авлага, эрдэм шинжилгээний сэтгүүлийн судалгаа, хүртээмж, хэрэглээ

- Виртуал, дижитал видео, аудио болон бусад цахим эх үүсвэрүүдийн байдал
- Цахим орчны хүртээмж, хэрэглээ
- Сургалт, судалгааны лицензтэй программын ашиглалтын байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БОХУ мэргэжлээр магистрын түвшний сургалтад нийт 793 ном ашиглагдаж байна.
- 2005-2017 онд шинээр авсан ном сурах бичгийн хангалт 66.4% байна. Үүнээс өөрийн сургуулийн багш нарын бүтээн туурвисан бүтээл 25 нэр төрлийн 155 ширхэг бүхий сурах бичиг 7.8%-ийг эзэлж байна. Ном, гарын авлагуудыг сүүлийн жилүүдэд төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр хэвлүүлэх байдал нэмэгдсэн.
- Магистр болон докторын бүтээлийн хураангуйн электрон файлыг ХАА-н төв номын сангийн эрдэм шинжилгээний фондод бүртгэн хадгалж, нийтэд ашиглуулж байна.
- ХААИС-ийн номын санд байгаа судалгааны ажлын мэдээллийн сангийн тухайд магистрын хэвлэмэл ажил 942, CD 1317, диссертаци 323, автореферат 1256, бусад гарын авлага 700 гаруй төрөл байна.
- 2010-2015 онуудад LIB4U программын сүүлийн үеийн хувилбаруудыг номын сангийн үйлчилгээнд нэвтрүүлсээр ирсэн байна.
- Нээлттэй, чөлөөт сонголттой уншлагын 2 танхимтай.
- Олон улсад нэр хүнд бүхий гадаадын 5 цахим мэдээллийн санг гэрээ байгуулан, ХААИС-ийн сүлжээнээс ашиглаж байна. Цахим номын сантай.
- Мэргэжлийн ангийн оюутнууд сургалт, судалгааны ажилдаа Arc Gis 10.1, 8.0, 10.3, Autocad 2015 газрын зургийн мөн Erdas Imagine 2014, Envi 5.0 сансрын зургийн программ хангамжуудыг хэрэглэж байна.
- Цахим их сургууль болох зорилт тавин ажиллаж байгаа нь сайшаалтай.

Анхаарах асуудал:

- Тайланд тус хөтөлбөрөөр магистрын түвшинд ашиглагдаж байгаа ном сурах бичгийн тоо ширхэг хоорондоо зөрүүтэй мэт байгааг нягтлан цэгцлэх (42-43-р талд)

Зөвлөмж:

- Уг хөтөлбөрөөр ахисан түвшний суралцагчийн үйлчлүүлсэн байдал, ном, сурах бичиг, гарын авлагын ашиглалт, хэрэглээний байдлыг цаашид нарийвчлан тодорхойлох нь зүйтэй юм.

2-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 3. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

Хөтөлбөрийн удирдлага нь сургуулийн алсын хараа, эрхэм зорилгод нийцүүлэн сургалтын үйл ажиллагааг чанартай, тасралтгүй явуулахад нөөцийг оновчтой хуваарилж; хөдөлмөрлөх, суралцах таатай орчинг бүрдүүлэн хөтөлбөрийн хөгжлийг хангахуйц стратеги, менежментийг хэрэгжүүлнэ.

3.1 Хөтөлбөрийн удирдлагын үйл ажиллагаа

Хөтөлбөрийн удирдлагын үйлчилгээ нь сургалтын чанарыг сайжруулахад чиглэж, нийгмийн хариуцлагатай, оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангадаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын удирдлага, мэдээллийн системийн ашиглалт, хяналт, ил тод байдал
- Хөтөлбөрийн нэгжийн /тэнхим, профессорын баг, хөтөлбөрийн хороо/ шийдвэр гаргалт, хэрэгжилтийн үнэлгээнд багш, суралцагчдын оролцоог нээлттэй, ил тод хангасан байдал
- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэхэд шаардлагатай дүрэм, журмуудын хэрэгжилт
- Урт болон богино хугацааны төлөвлөлт, гүйцэтгэлийн тайлан, ахиц өөрчлөлтийн дүн шинжилгээ механизм
- Санал, гомдол хүлээн авах, хариу өгөх үйл ажиллагаа, систем бүрдсэн байна.
- Хөтөлбөрийн багш, ажилтнуудын хүний нөөцийн судалгаа, шинжилгээ, хөгжүүлэх ажлын үнэлгээ, гүйцэтгэлийн болон үр дүнгийн урамшууллын хэрэгжилт

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын түвшний сургалтанд удирдлагын мэдээллийн OneMIS удирдлагын мэдээллийн системийг ашиглаж эхэлсэн. Энэ систем нь суралцагчийн элсэн орохоос эхлэн төгсөх хүртэлх сургалтын үйл ажиллагааны бүх мэдээллийг цогц байдлаар бүрдүүлдэг, интранет (дотоод сүлжээ), интернетийн орчинд ажилладаг давуу талтай. Мөн eliademy мэдээллийн системийг нэвтрүүлж, хөтөлбөрийн хичээлийг онлайн хэлбэрээр үзэх боломжийг бүрдүүлсэн. Магистрын хөтөлбөрт элсэн суралцагчид ХААИС-ын магистр, докторын сургуулийн вэб хуудаснаас хөтөлбөртэй холбоотой эрх зүйн болон өдөр тутмын ажлын мэдээллийг авах боломжтой. Уг удирдлагын мэдээллийн эдгээр системийг ашигласнаар хөтөлбөрийн хэрэгжилтийг хянах, багш, суралцагчийн, суралцах, сургах үйл ажиллагааг үнэлж дүгнэх, зөвлөх, цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зэрэг үйл ажиллагааны нээлттэй байдлыг бий болгосон байна.
- ХААИС-ын захирлын 2015 оны 06 сарын 11-ны А/192 тушаалаар БОХУ хөтөлбөрийн хороо байгуулсан. Хөтөлбөрийн сургалтын чанар, сургалтын хөтөлбөрийн үр дүн, үр өгөөжийг сайжруулахын тулд төгсөгчид, багш, ажил олгогчид, мэргэжлийн байгууллагаас сэтгэл ханамжийн судалгаа БОХУ

хөтөлбөрийн хүрээнд авч, тухайн мэдээлэлд дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланд болон тэдний саналд үндэслэн Хөтөлбөрийн хорооны хурлаар сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулдаг.

- Хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх шаардлагатай дүрэм, журмууд (Хичээлийн хөтөлбөр боловсруулах заавар 2014.10.24 А/62)-ын шаардлагад нийцүүлж хөтөлбөрөө шинэчилсэн. Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт, мониторинг, үнэлгээ хийх, шалгуур үзүүлэлтийг боловсруулж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нь БОХУ хөтөлбөрийн стратеги төлөвлөгөөнд туссан.
- БОХУ хөтөлбөрөөр суралцагчийн зүгээс өргөдөл, санал, хүсэлт одоогоор гаргаагүй.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийг багаараа боловсруулах, хөтөлбөрөө тасралтгүй сайжруулах, шинэчлэх үйл ажиллагаанд багш нарын оролцоог жигд хангах байдал учир дутагдалтай байна.
- Орон нутгийн болон ААНБ-ын хүсэлтээр алсын зайн болон экстернат, эчнээ хэлбэрээр магистрын сургалт зохион байгуулах талаар авч буй арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай нь харагдлаа.

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж байгаа ХААИС-ын МДС-ийн нэгж болон хэрэгжилтийг хангаж буй АЭС, хөтөлбөрийн нэгжүүдийн чиг үүргийг тодорхой болгож, харилцан хамтын ажиллагаа, уялдаагаа сайжруулах, хөтөлбөрийн хэмжээнд нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх шаардлагатай.

3.2 Хөтөлбөрийн маркетингийн идэвхжүүлэлт

Хөтөлбөр нь тогтвортой байдлаа хангахуйц идэвхжүүлэлтийн хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны давтамж
- Хөтөлбөрийн сурталчилгаа, идэвхжүүлэлтийн арга хэлбэр, хүртээмж, үр нөлөө

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- ХААИС-ын захирлын 2015 оны А/61 тоот тушаалаар батлагдсан “ХААИС-ийн маркетинг идэвхжүүлэлтийн хөтөлбөр”-ийн дагуу Хөтөлбөрийг дэмжих маркетинг идэвхжүүлэлтийг хийж байгаа бөгөөд энэ хүрээнд орон нутагт “ХААИС-ын элч оюутан” илгээх, залуу судлаачдыг дэмжих грант олгох, шилдэг бүтээлд мөнгөн урамшуулал олгох, төлбөрийн хөнгөлөлт болон хээрийн судалгааны ажлын зардлын дэмжлэг үзүүлэх зэрэг ажлууд тогтмол хийгдэж үр дүнтэй хэрэгжсэн.
- Хөтөлбөрийн сурталчилгааг ХААИС-ийн Ногоон хөгжил дижитал студийг БОХУ хөтөлбөрийн ахлагч хариуцан ажиллаж, хөтөлбөрийн танилцуулга, видео

хичээлийг бэлтгэн, хэвлэл мэдээллийн хэрэгсэл (МҮОНРТ)-ээр хөтөлбөрөө сурталчилсан нэвтрүүлэг хийж хэвшсэн нь сайшаалтай байна.

Анхаарах асуудал:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааны мэдээлэл, тоо баримтад нарийвчилсан шинжилгээ хийж, төгсөгчдийн ажиллах боломжтой ажлын байруудад тавигдах шаардлага, шалгуурыг хөтөлбөрийн үйл ажиллагаатай уялдуулахад анхаарах

Зөвлөмж:

- Хөдөлмөрийн зах зээлийн тандан судалгааг тодорхой давтамжтай явуулах, үр дүнг харьцуулан шинжлэх, үйл ажиллагаандаа тусгаж ажиллах
- Хөтөлбөрийн хичээлүүдийг цахим хэлбэрт шилжүүлж, орон нутгийн болон ААНБ-ын хүсэлтээр алсын зайн болон экстернат, эчнээ хэлбэрээр магистрын сургалт зохион байгуулах чиглэлээр маркетинг идэвжүүлэлтийг хийх

3.3 Төгсөлтийн дараах бодлого

Хөтөлбөр нь төгсөгчидтэйгээ байнгын эргэх холбоотой, тэдний мэргэжлийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулж, төгсөгчид нь суралцаж буй суралцагчдад мэргэжлийн чиглэлээр ажиллахад нь зөвлөн тусладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгаа
- Үргэлжлүүлэн суралцагчдын хувь хэмжээ
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлого, төлөвлөгөө, хамрагдсан байдал
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааны тогтмолжсон байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төгсөгчдийн карьерын өсөлтийн судалгааг ХААИС-ын МДС нь 2017 оноос хийж эхэлсэн. БОХҮ хөтөлбөрөөр магистрын түвшинд суралцаж төгссөн 54 төгсөгч бүгд мэргэжлээрээ ажилладаг, үүний 15% нь удирдах албан тушаалд дэвшин ажиллаж байна.
- ХААИС-ын БОХҮ хөтөлбөрт нийт элсэн суралцагчдын 70 орчим хувь нь үргэлжлүүлэн суралцагчид бол уг хөтөлбөрөөр суралцаж төгсөгчдийн 14% нь үргэлжлүүлэн докторантурт элсэн суралцсан.
- Төгсөгчдийг давтан сургалтад хамруулах асуудлыг БОХҮ хөтөлбөрийн стратеги төлөвлөгөө /2017-2032/-нд “Төгсөгчдийг давтан сургах, мэргэжил дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэх” гэж тусган хэрэгжүүлж эхэлсэн. Төгсөгчидтэй өнгөрсөн хугацаанд 3 удаа сургалт, уулзалт зохион байгуулж, 2.5 кр цагийн багтаамжтай сургалт зохион байгуулсан.

- БОХУ хөтөлбөрөөр ахисан шатанд суралцаж төгсөгчид одоогоор холбоо байгуулаагүй боловч БОХУ хөтөлбөрийн стратегийн төлөвлөгөө /2017-2032/-нд “төгсөгчидтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх” асуудлыг тусгасан байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчидтэй эргэх холбоотой байх үйл ажиллагаа тогтмолжоогүй нь сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд төгсөгчдийн зүгээс бодитой хувь нэмэр оруулахгүй байна гэж үзэх үндэстэй.

Зөвлөмж:

- Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгад зааснаар төрийн албан хаагчид жил бүр тодорхой кредит цагийг биелүүлэх сургалтад хамрагдах шаардлагатай гэсэн заалтын хэрэгжилттэй БОХУ хөтөлбөрийн төгсөгчдийг давтан сургалтад хамруулах бодлогыг уялдуулахад анхаарах
- Төгсөгчдийн холбоог байгуулах, хөтөлбөрийн багш нар төгсөгчдийн холбоогоор дамжуулж болон төгсөгчидтэй цахим хэлбэрээр мэдээлэл солилцож, хамтран ажиллах замаар тэдний сургалтын хэрэгцээг тодорхойлох
- Төгсөгчдийн холбооны үйл ажиллагааг тус сургалтын хөтөлбөрийн чанар, төгсөгчдийн мэдлэг, ур чадварыг тасралтгүй сайжруулж байхад чиглэсэн бүтээлч, үр өгөөжтэй арга хэлбэрээр тогтмолжуулах

3.4 Олон улсын харилцаа, хамтын ажиллагаа

Олон улсын их дээд сургуулиуд, судалгааны болон мэргэжлийн байгууллагуудтай холбоо тогтоож; багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт ба хамтарсан хөтөлбөр, сургалт, судалгаа, семинар зэрэг хэлбэрээр хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хэрэгжүүлж буй хамтарсан төсөл, хөтөлбөрүүдийн тайлан, дүгнэлт
- Багш, суралцагч солилцоо, тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдагсдын тоо
- Олон улсын хурал семинар, судалгаа болон бусад арга хэмжээнд оролцсон тоо, үр дүн, ач холбогдол

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БОХУ хөтөлбөрийн хүрээнд 10 гаруй орны 20 гаруй их сургууль, ЭШ-ний байгууллагад 30 гаруй суралцагч, 20 гаруй багш хурал, сургалтад хамрагдсан байна. Эдгээрт хамрагдах явцад хамтарсан төсөл, судалгааны ажил хэрэгжүүлэх боломж нөхцөлийг судалж байгаагийн дүнд 2015 оны байдлаар 2 олон улсын хамтарсан төслийг хэрэгжүүлсэн.
- Төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр мэргэжлийн хөтөлбөрийн гадаад харилцаа өргөжиж, багш, оюутны солилцоо, мэргэжил дээшлүүлэлт нь нэмэгдсэн. Хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд багш, оюутан солилцоо 2001 оныхтой харьцуулахад 2015 онд 8 дахин нэмэгдсэн байна.

- БОХУ хөтөлбөрт хичээл заадаг багш нар болон хамрагддаг оюутнууд олон улсын хурал, семинар, сургалтад оролцохоос гадна гадаадын их сургуульд зочин профессороор ажиллах, нэр хүндтэй эрдэм шинжилгээний сэтгүүлийн редакцийн зөвлөлд ажилладаг байна. Түүнээс гадна БОХУ хөтөлбөрийн хүрээнд Чех, Герман улсаас суралцагч ирж уг хөтөлбөрийн 4-6 хичээлийг англи хэл дээр сонгон судалсан нь багш нарын чадавхыг илтгэн харуулж байна.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн багш нарын ОУЭШХ-д оролцсон илтгэлүүдийн сэдэв, агуулга нь хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад чиглэсэн гэхээсээ илүү тухайн судлаачийн судалгааны чиглэл, сонирхолд хөтлөгдсөн байдал ажиглагдаж байна.
- Багш нарын олон улсын эрдэм шинжилгээний хуралд танилцуулсан илтгэл, хамтарсан судалгааны тайлан зэрэг гадаад хэлээр /англиас бусад хэл ашигласан/ бичигдсэн бүтээлийг тодорхой хэмжээгээр орчуулах, суралцагчдад ашиглах боломжийг нэмэгдүүлэх

Зөвлөмж:

- Олон улсын хамтарсан судалгаа, төсөл, хурал, семинар, сургалтын сэдэв, чиглэлийг БОХУ хөтөлбөрийн хэрэгжилттэй уялдуулахад анхаарах
- БОХУ хөтөлбөрөөр элсэн суралцагчдын гадаад хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, олон улсад гарч ажиллах чадвартай мэргэжилтэн бэлтгэх

3.5 Дотоод хамтын ажиллагаа, нийгэмд үзүүлэх үйлчилгээ

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нь мэргэжлийн холбоод, үйлдвэр, үйлчилгээний байгууллагууд, ажил олгогч эздийн холбоо, төрийн болон ТББ-уудтай хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хамтран ажиллах гэрээ, хэлцэл, ажлын үр дүн
- Хэрэгжүүлж буй ажлуудын тайлан, дүгнэлт
- Хамтын ажиллагааны арга, туршлага
- Нийгэмд үзүүлсэн үйлчилгээний хэлбэр, хамрагдагсдын тоо үр дүн /багш, суралцагчдын зүгээс/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн хүрээнд 2013-2018 онд 4 чиглэлээр 50 гаруй ААНБ-тай хамтын ажиллагааг үйлдвэрийн дадлага, танилцах дадлага, судалгаа, зөвлөх үйлчилгээ, үнэлгээ, сургалт, семинар, материаллаг дэмжлэг гэсэн чиглэлээр хамтын ажиллагаа хөгжүүлж үр дүнд хүрсэн байна.
- Хамтын ажиллагааны арга туршлагад БОНБНУ хийх ажил давамгайлж, судалгаа, сургалт, зөвлөх үйлчилгээний ажил олонтоо хийгдэж, үүний үр дүнгээр 20 гаруй магистрант судалгаа, шинжилгээний ажлаа хийж, сургалтын орчинд

тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт материал, тоног, төхөөрөмж нэмэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Хамтын ажиллагааны арга туршлагад БОНБНҮ хийх ажил давамгайлж байгаагаас харахад хөтөлбөрийн мэргэшүүлэх хичээл заадаг багш нар, профессоруудын ажлын чанар, ажилдаа зарцуулах цагт сөргөөр нөлөөлж болох тул зохистой байдлыг хангах

Зөвлөмж:

- БОХҮ хөтөлбөрийн хүрээнд ижил төстэй хөтөлбөр хэрэгжүүлдэг их, дээд сургуулиуд, түүний лабораториудтай хамтарч ажиллах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх дотоод хамтын ажиллагааны хүрээнд ажил олгогчийн томоохон төлөөлөл болох орон нутгийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгаль орчны салбартай хамтын ажиллагааг өргөжүүлэх

3.6 Санхүүжилт

Хөтөлбөрийн санхүүжилтийн тодорхой хувь нь багш, суралцагчийн хөгжилд зарцуулагддаг, олон эх үүсвэртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төсөв, санхүүгийн бие даасан байдлын хөгжил
- Нэг суралцагчид ноогдох өртөг зардлын тооцоо
- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсөв
- Төр хувийн хэвшлийн дэмжлэг, санхүү түүний зарцуулалт
- Төсвийн уламжлалт бус эх үүсвэр, бүрдүүлэлт, хуваарилалт, санхүүжилт

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл / Туршлага:

- 2018 оноос ХААИС-ын МДС дэд данс нээж, сургалтаас олох орлогыг төвлөрүүлсэн. 2017-2018 оны хичээлийн жилд нийт орлого 563,1 сая төгрөг болсон нь өмнөх оны үеийн гүйцэтгэлээс 31.1% буюу 133,5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- БОХҮ хөтөлбөрт суралцагсдын төлбөр төлөлт жил бүр нэмэгдсэн ба 2017-2018 оны санхүүгийн тайланд МДС-ын төлбөр төлөлтийн мэдээгээр БОХҮ хөтөлбөр Эдийн засгийн хөтөлбөрийн дараа 2-рт эрэмблэгдэж, ХААИС-ийн түвшинд эдийн засгийн ашигтай хөтөлбөрт тооцогддог байна.
- Нийт орлогод орлогуудын эзлэх хувийн жинг үзэхэд сургалтын төлбөр 70%, төслийн санхүүжилт 9%, туслах үйл ажиллагааны орлого 21%-ийг бүрдүүлж байна. Зардлын бүтцийн хувьд авч үзвэл тайлант онд нийт зардлын хөтөлбөрийн санхүүгийн 74% нь сургалттай холбоотой шууд зардалд, 9.8% нь сургалттай

холбоотой шууд бус, 16.2% нь хөрөнгө оруулалттай холбоотой зардал эзэлдэг байна.

- Санхүүжилтийн олон эх үүсвэрийг бий болгох, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх талаар санаачилга гарган ажилладаг, төсвийн тодорхой хувь нь багшийн хөгжлийг дэмжих сургалт, томилолт зэрэг ажилд зарцуулагддаг ба нэг суралцагчид оногдох өртөг зардал тооцож төсөвлөдөг, сүүлийн жилүүдэд энэ зардал нь тогтмол нэмэгдэж байгаа.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүнд чиглэгдсэн шинэчлэлт, өөрчлөлтөд зориулсан төсвийн талаарх мэдээлэл хангалтгүй байна.
- Хөтөлбөрийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх зорилгоор профессор, багш нарын бүтээлийг инноваци болгох, түүнд суурилсан гарааны компани байгуулах чиглэлд анхаарал хандуулж ажиллах

Зөвлөмж:

- Хөтөлбөрт суралцагсдын сургалтын төлбөрийн тодорхой хувийг сургалтын чанарыг сайжруулах, хүртээмжийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээллийн технологи нэвтрүүлэхэд зарцуулах боломжийг бүрдүүлэх
- БОХУ хөтөлбөрийн санхүүжилт, төсвийн нэгдсэн тайлан мэдээ гаргах, хянах

3-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 4. Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа

Тухайн хөтөлбөрөөр суралцагчдын оролцоог ханган бие даан амжилттай суралцахад чиглэсэн дэмжих үйл ажиллагааг хүртээмжтэй, ашиг сонирхолд нь нийцүүлэн үр дүнтэй хэрэгжүүлдэг байна.

4.1 Суралцагч сонгох, элсүүлэх

Хөтөлбөрийн онцлогт тохирсон шалгуураар элсэгчдийг сонгон шалгаруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрийн онцлогт нийцсэн шалгуурыг тусгасан байдал
- Элсэгчдийн ЕШ-ийн дундаж оноо, хүсэлт гаргасан болон элссэн суралцагчдын харьцаа
- Шинээр элссэн суралцагчдыг чиглүүлэх сургалтад хамруулж, мэдээлэл, гарын авлагаар хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагч элсүүлэх эрх зүйн зохицуулалтад хөтөлбөрт элсэгч нь бакалавр болон түүнтэй дүйцүүлэх боловсрол эзэмшсэн байх, хэрвээ гадаад бол монгол хэлээр сургалтад хамрагдах боломжтой байх, бакалаврын түвшинд БОХУ мэргэжлээс өөр чиглэлээр төгссөн бол 15-30 кр цагийн хичээлийн зөрүүг үзэх гэсэн шалгуурыг хангахаар тусгасан байна.
- Хөтөлбөрт элсэхээр бүртгүүлэгч болон элсэн суралцагчдын тооны харьцаа 100:90 байна.
- Шинээр элсэн суралцагч мэдээллийг ХААИС-ийн цахим хуудаснаас элсэлтээс эхлэн суралцах хугацааны мэдээлэл, мэргэжлийн хөтөлбөрүүд, тэдгээрийн чиглэлийн талаар мэдээлэл авдаг. Хөтөлбөрт элсэн суралцагчдад зориулсан гарын авлага гаргасан.

Анхаарах асуудал:

- Уул уурхайн хөгжил, байгаль орчны асуудал чухлаар тавигдаж байгаа өнөө үед тус хөтөлбөрт элсэн суралцагчдын тоо нэмэгдэж байгаатай холбоотойгоор элсэгчдэд хөтөлбөрийн онцлогт нийцсэн нарийвчилсан шалгуур тусгах шаардлага үүсч болохыг анхаарах.

Зөвлөмж:

- Хөтөлбөрт элсэгчдийн элсэлтийн шалгалтын нэгдсэн дүнгээр бие даасан мэдээллийн сан үүсгэх

4.2.Зөвлөн туслах үйлчилгээ

Суралцагчдад суралцах, судлах арга зүй, ирээдүйн ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт, сэтгэл зүй, хууль эрх зүйн чиглэлээр зөвлөх үйлчилгээг тогмол, чанартай үзүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Зөвлөх, хөгжүүлэх үйлчилгээний төлөвлөгөө, график, үр дүн
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, сургалтын менежер, арга зүйч, байрны багш, эмч, сэтгэл зүйч нарын үйлчилгээний чанарын үнэлгээ, сайжруулалт
- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйн /зан үйл, зөрчил шийдвэрлэх, эрүүл аж төрөх г.м/ чиглэлүүдээр сургалт явуулж, ур чадвар олгодог байдал
- Суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлдэг байдал
- Суралцагч, төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлдэг байдал
- Суралцагчийн судалгаа, шинжилгээний үйл ажиллагааг дэмжин тусалсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчид өөрсдийн судалгааны чиглэлийг харгалзан хичээл сонголт хийдэг, удирдагч багшийн тусламжтайгаар судалгааны арга зүйгээ боловсруулан батлуулж, судалгааны ажлаа төлөвлөн ажилладаг. Суралцагч хүссэн үедээ хөтөлбөрийн профессор багш нараас зөвөлгөө авах боломжтой.
- МДС нь удирдлага мэдээллийн Элиадеми системийг ашигласнаар суралцагч тухайн системд хандан хөтөлбөрийн хичээл, профессор багшийн талаарх мэдээллийг авах, онлайн хичээл үзэх боломж бүрдэж эхэлсэн байна.
- Зөвлөх багш, сургалтын туслах ажилтан, арга зүйч нарын үйлчилгээний чанарыг төгсөгчийн сэтгэл ханамжийн судалгаанд нөлөөлөгч хүчин зүйл болгон авч үзэж дүн шинжилгээ хийхэд сэтгэл хангалуун гэсэн үнэлэлтийг өгсний зэрэгцээ суралцагчидтай хийх ярилцлагаар мөн энэ нь нотлогдсон.
- Эрдэм шинжилгээний хурал, онолын болон судалгааны семинар зохион байгуулж, гадаад орны профессорыг урьж, орчин үеийн судалгааны арга зүй, техник технологийн чиглэлээр сургалт явуулах зэргээр суралцагчдын суралцах арга зүй, судалгааны ажлыг нь дэмжиж ажилладаг.
- Оюутны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвтэй хамтран ажиллах, экологийн тэнхимийн төгсөгчдийн холбоо болон АЭС-ын группээр дамжуулан төгсөгчдөд хөдөлмөрийн биржийн үйлчилгээ үзүүлэх ажлыг хийдэг.

Анхаарах асуудал:

- Бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйг дээшлүүлэх, суралцагчийн сайн дурын ажлыг үнэлэх чиглэлээр тодорхой ажлыг хэрэгжүүлэхэд МДС сургууль, БОХУ хөтөлбөрийн нэгжээс анхаарах

Зөвлөмж:

- БОХУ хөтөлбөрийн төгсөгч нь байгаль орчны хяналт хийх, шинжээч, аудитор болохыг харгалзан үзэж, эдгээрт бие хүний төлөвшил, харилцаа, ёс зүйг дээшлүүлэх ялангуяа ёс зүйг дээшлүүлэх талаар сургалт, бусад арга хэмжээг зайлшгүй зохион байгуулах

4.3.Оюутны байгууллагад үзүүлэх дэмжлэг

Оюутны байгууллагаас санаачилсан нийгэмд үзүүлэх үйлчилгээг дэмжин хамтран ажилладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оюутны сайн дурын үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангаж, дэмжсэн байдал
- Оюутны байгууллагын үйл ажиллагааг явуулах төсөв, клубын үйл ажиллагааг дэмжих санхүүжилттэй байх, зориулалтын дагуу зарцуулдаг байдал
- Оюутны байгууллагын зүгээс санхүүгийн зарцуулалтаа ил тод тайлагнадаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 оныг хүртэлх хугацаанд магистрант оюутны сайн дураар зохион байгуулсан ажлын талаар сургалтын кредит тооцох эрх зүйн зохицуулалт байгаагүй...” гээд “хөтөлбөрийн стратеги төлөвлөгөөний идэвхжүүлэлтийн хэсэгт суралцагчийн гүйцэтгэсэн сайн дурын ажлыг үнэлэх эрх зүйн зохицуулалтыг оруулахаар санал өгөхөөр оруулсан байгаа” хэмээн тус сургууль өөрийн үнэлгээний тайландаа онцолсон байна.

Анхаарах асуудал:

- БОХУ хөтөлбөрт суралцагчдад хамтран сайн дурын ажил явуулах, эвлэлдэн нэгдэх хэрэгцээ шаардлага байгаа эсэхийг тандах энэ чиглэлд суралцагсдын анхаарлыг хандуулах

Зөвлөмж:

- Хөтөлбөрт элсэн суралцагчдад судалгаа, эрдэм шинжилгээний ажлын чиглэлээрээ эсвэл эрхэлж байгаа ажлын дагуу эвлэлдэн нэгдэх, сайн дураараа бүлэг үүсгэх, харилцан туршлага солилцох арга хэмжээг дан ганц эрх зүйн зохицуулалт байхгүйтэй холбон, хэрэгжээгүй мэт тайлбар өгөх нь учир дутагдалтай байгааг анхаарч, өөр үр нөлөөтэй арга зам, боломжит хувилбарыг эрэлхийлэх нь зүйтэй.

4.4. Суралцагчийн урамшууллын тогтолцоо

Суралцагчдын амжилтыг хөхүүлэн дэмжих урамшууллын системтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд хамрагдсан суралцагчдын тоо
- Суралцагчдын үзүүлсэн амжилтууд
- Сургуулиас үзүүлж буй урамшуулал, дэмжлэг

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Төрөөс олгодог болон ХААИС-ын ахисан шатанд суралцагчдад олгох урамшуулал, тэтгэлэг хөнгөлөлтөд БОХУ хөтөлбөрт суралцагчдын 50 орчим хувь нь хамрагдсан.
- БОХУ хөтөлбөрөөр суралцагсад дотоодын болон олон улсын эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлж тэргүүн болон шагналт байр эзэлсэн, зарим суралцагсад төгсөөд албан тушаал ахих, ажил мэргэжлийн аврага болох болон докторантурт элсэн суралцаж байна.

- Элсэн суралцагчийн голч дүн 3.2 ба түүнээс дээш байвал шалгалтгүй элсэх, төлбөрийн 15%-н хөнгөлттэй суралцах, төрөл бүрийн зээл, тэтгэлэгт хамрагдах, үйлдвэрчний эвлэлтэй байгуулсан гэрээний дагуу багшилдаг суралцагчийн төлбөрийг 50% хөнгөлөх зэрэг олон хэлбэрийн урамшуулал тодорхойлсон байна.

Анхаарах асуудал:

- Олон улсын чанартай эрдэм шинжилгээний хурал, уралдаан тэмцээнд суралцагчдын оролцоог нэмэгдүүлэх шаардлагатай.

Зөвлөмж:

- Оюутнаа судалгааны ажилд татан оролцуулж, амжилт гаргасан тохиолдолд зөвхөн оюутан бус багшийг хамтад нь урамшуулах тогтолцоог бий болгох

4.5. Суралцагчийн шилжилт, хөдөлгөөн

Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ холбогдох дүрэм, журмын дагуу суралцагчийн эрх ашигт нь нийцүүлэн шийдвэрлэдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэсэн байдал
- Шилжилт хөдөлгөөний судалгаа, дүгнэлт
- Шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй дүрэм, журам, гэрээний хэрэгжилт, суралцагчийн эрх ашгийг дээдэлсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Суралцагчийн шилжилт хөдөлгөөнийг ХААИС-ийн магистрын сургалтын журмын дагуу шийдвэрлэнэ. Одоогоор БОХҮ хөтөлбөрт элсэгчдээс өөр хөтөлбөрт шилжилт хөдөлгөөн бүртгэгдээгүй, харин уг хөтөлбөр рүү 30 магистрант шилжин ирсэн.
- Хөтөлбөрийн хүрээнд гадаадын нэр хүнд бүхий сургуульд суралцсан магистрантын 15, дотоодын ижил түвшний сургуульд суралцсан бол 10 багц цагийг тооцуулж болохоор зохицуулсан байна.
- Шилжилт хөдөлгөөнийг шийдвэрлэхдээ /кредитийг хүлээн зөвшөөрөх, дүйцүүлэн тооцох, кредитээс чөлөөлөх/ сургуулийн хүрээнд мөрдөгдөж буй дүрэм, журмыг хэрэгжүүлж, суралцагчийн эрх ашгийг дээдлэхэд анхаардаг.

Анхаарах асуудал:

- Элсэгч, төгсөгчдийн тооны зөрүү их байгаа ба энэ нь элсэгчид идэвхтэй суралцахгүй орхих, жилийн чөлөө авах, төлбөрийн чадваргүй зэргээс шалтгаалж байгаа тул нэгэнт элсэн орсон суралцагчдыг сонгосон хөтөлбөрөөр нь амжилттай суралцах боломжийг олгох

Зөвлөмж:

- Сургалтын төлбөр төлөх боломжгүй сургуулиас гарах, жилийн чөлөө авч буй оюутнуудыг зээлийн санд хамруулах, судалгааны төсөлд ажиллуулах тогтолцоог бүрдүүлэх

4-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 5. Багшийн үйл ажиллагаа

Багшийн үйл ажиллагаа нь хөтөлбөрийн үр дүнг амжилттай хэрэгжүүлж, хөгжүүлэхэд чиглэсэн байна.

5.1.Багшийн сонгон шалгаруулалт, албан тушаал, урамшууллын бодлого

Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн хүний нөөцийн цогц бодлого: тушаал, урамшууллын бодлого Хөтөлбөр нь тавьсан зорилго, зорилтоо хангахуйц онол дадлагыг зохистой хэмжээнд эзэмшсэн эрдмийн зэрэг цолтой, сургалтын арга зүйн өндөр ур чадвартай, мэргэжлийн туршлага бүхий багшийн нөөцтэй байна. сонгон шалгаруулалт, хөгжүүлэлт, төлөвлөлт, хэрэгжилт
- Доктор зэрэгтэй багш нарын эзлэх хувийн жин
- Багш суралцагчдын тооны зохистой харьцаа
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлагыг мөрддөг байдал
- Гүйцэтгэлийн болон чанарын үнэлгээнд суурилан багш нарыг урамшуулдаг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017-2018 оны хичээлийн жилд экологийн тэнхимийн 28 багш сургалтын үйл ажиллагаа явуулж байгаагийн 17 багш нь БОХУ хөтөлбөрт үйлчилгээ үзүүлдэг

бөгөөд эдгээрээс доктор цолтой 11 багш буюу 64,7 хувь нь ахисан түвшинд сургалт явуулж байна. /x111/

- Нэг багшид ноогдох магистрантын тоо дунджаар 4-5 байгаа нь суралцах хугацаанд багш нарын хүртээмж хэвийн байна./x112/
- Багшийн албан тушаалын зэрэглэлийн ангилалд тавигдах шаардлага Дээд боловсролын тухай хуулийн 7-р бүлгийн 13.3-д заасны дагуу 5-н шатлалтай албан тушаалд багш нар хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна.
- Багшийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлдэг.
- Үндсэн орон тоон дээр ажиллаж байгаа профессор багшийн үр дүнгийн гэрээ үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг жил бүр дүгнэдэг.
- Докторантурт суралцагчдын сургалтын төлбөрийг 50 хувь хүртэл хөнгөлөлт үзүүлж 3 хүртэл сарын цалинтай бүтээлийн чөлөө олгож багш нараа дэмжиж ажилладаг.

Анхаарах асуудал:

- Хяналт, үнэлгээний чиглэлээр ажилладаг багш тэнхимд цөөн тул энэ чиглэлийн багшид ирэх ачаалал өндөр байна.
- Багш нарын ачааллыг тэнцвэртэй байлгахын тулд технологи, хяналт, үнэлгээний чиглэлээр багш нарыг мэргэшүүлэх.

Зөвлөмж:

- Цаашид багш нарыг гадаадад мэргэжил дээшлүүлэхэд сургуулиас тодорхой дэмжлэг туслалцаа үзүүлэх шаардлагатай.
- Хөтөлбөрийн онцлогт тохирсон мэргэжлийн чиглэлээр багш авах асуудлыг сургуулийн захиргаа анхаарч ажиллах нь зүйтэй.

5.2. Багшийн хөгжил

Мэргэжлийн болон сургалт, эрдэм шинжилгээний мэдлэг, арга барил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн багшийн хөгжлийн хөтөлбөртэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Багшийн мэргэжил; заах арга зүйн ур чадвар; эрдэм шинжилгээ, судалгааны арга зүйн түвшин; суралцах хэрэгцээг тодорхойлох судалгааг тогтмол хийдэг байдал
- Багшийн хөгжлийн хөтөлбөр, хэрэгжилт, дүн шинжилгээ, сайжруулалт
- Багшийг үе шаттай хөгжүүлж, урт богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулдаг байдал
- Гадаад, дотоодод туршлага судлуулсан байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багшийн хөгжлийн хөтөлбөрийг ХААИС 2002, 2010, 2017 онуудад боловсруулан гаргаж, хөтөлбөрт багшийг үе шаттай хөгжүүлэх, урт, богино хугацаанд мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлж чадавхжуулах зэрэг олон талт ажлыг хэрэгжүүлж эхэлсэн байна.
- Эрдмийн зэрэг цолтой багшийн эзлэх хувь их бөгөөд экологийн тэнхимийн 64,7% нь доктор цолтой байна.
- Эрдмийн зэрэгтэй багш нарын тал хувь нь гадаадад эрдмийн зэрэг хамгаалсан байна.
- БОХяналтын чиглэлийн сургалт сайтай.
- Монгол улсын ЦЕГ-ын харьяа МБА, ЭЦГ, ЕПГ зэрэг хууль хүчний байгууллагуудтай нягт хамтран ажилладаг
- Улсын хэмжээний том хэргүүд дээр ажилладаг магистрантуудаа энэхүү ажиллагаанд оролцуулдаг, дадлага хийлгэдэг
- Байгаль орчны үнэлгээний мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилладаг магистрантуудаа мэргэшүүлж чадавхжуулдаг.

Анхаарах асуудал:

- Олон доктор багштай боловч ургамал, таримал судлалын чиглэлээр багш нар олонтой тул элссэн магистрантуудын эрэлтийг хангах тал дээр анхаарах.

Зөвлөмж:

- Багш нарын ачааллыг тэнцвэртэй байлгахын тулд технологи, хяналт, үнэлгээний чиглэлээр багш нарыг мэргэшүүлэхэд анхаарч ажиллах хэрэгтэй.

5.3.Эрдэм шинжилгээ, судалгаа

Багш эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг тогтмол хийж, судалгааны үр дүн нь хөтөлбөр хэрэгжүүлэхэд үр нөлөөтэй байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Боловсролын болон шинжлэх ухааны шинэ туршилт, инноваци, патентийн тоо
- Захиалгат төсөл, гэрээт ажилд оролцсон байдал
- Судалгааны ажлын үр дүнгээр хөтөлбөрийн сургалтын агуулга, арга зүй; судалгааны ажил шинэчлэгдэн хөгжсөн байдал
- Үндэсний болон олон улсын нэр хүндтэй хэвлэлд нийтлэгдсэн бүтээл, судалгааны ажил, эшлэгдсэн байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БОХУ хөтөлбөрийн багш нар зохиогчийн эрхийн 12 гэрчилгээтэй.
- Хөтөлбөрийн багш нар мэргэжлийн чиглэлийн дагуу 100 хувь эрдэм шинжилгээний төсөл, захиалгат болон гэрээт ажлуудад хийдэг бөгөөд

магистр оюутнуудыг оролцуулан судалгааны арга зүй, мэдээллийг боловсруулах үйл ажиллагаанд сургаж байна.

- Багш нарын нийт 12 шинэ бүтээл, 248 гэрээт ажил, нэр хүнд бүхий хэвлэлд нийтлэгдсэн бүтээл үндэсний 298, олон улсад 103, судалгааны ажил ишлэгдсэн байдал 213 байна. /х.119/
- Олон улсын эрдэм шинжилгээний бүтээлд IF –тэй сэтгүүлд 18 бүтээл хэвлэгдсэн байна. /х.121-122/

Анхаарах асуудал:

- Багш нарын судалгааны ажлын үр дүнгээр сургалтын хөтөлбөр дэх хичээлүүдийн агуулга, арга зүйг шинэчилж хөгжүүлдэг байдал дутмаг байна.

Зөвлөмж:

- Судалгааны ажлын үр дүнгээр сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, шинэчлэн сайжруулах талаар санаачилгатай ажиллах шаардлагатай.

5.4.Багшийн үнэлгээ

Багшийн сургалт, заах арга зүй, эрдэм шинжилгээ, судалгаа, мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээний /зөвлөх үйлчилгээ/ чиглэлээр хичээлийн жил тутам өөрийн болон хөндлөнгийн үнэлгээг тогтмол гүйцэтгэж, үр дүнг тооцдог байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Өөрийн үнэлгээний тайлан
- Багшийн хөндлөнгийн үнэлгээ /Аттестатчлал, эрэмблэлт, чансаа тогтоолт/
- Сургалтад ашиглаж буй сургах/заах аргын үр дүн, үр нөлөөний судалгаа
- Тайлан, судалгааг хэлэлцэж, дүгнэлт гаргасан байдал
- Сургалтад оролцогчдоор багшийг үнэлүүлэх
- Багшийн бүхий л үйл ажиллагааны баримт, материал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Багш бүр өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөгөө сургалт, эрдэм шинжилгээ, бүтээлч ажил гэсэн шалгуур үзүүлэлтээр төлөвлөж, гүйцэтгэж, тайлагнадаг.
- Багш бүр өөрийн үнэлгээний тайлан бичиж, тэнхимийн хамт олны хурлаар хэлэлцүүлж, захиргааны зөвлөлөөр дүгнүүлдэг.
- Багшийн хөгжил хөтөлбөрийг 2018 оноос боловсруулан хэрэгжүүлж байгаа бөгөөд профессор багшийн мэдлэг, оюуны чадамж, хувь хүний чадамж, судалгааны чадамж, сургахуйн чадамжийг үнэлэх шалгалт авч үнэлэн, албан тушаалын зэрэглэлийг тогтоон ажиллаж байна.

- Бакалаврын шатны оюутнуудаас багшийн сургалтын арга зүй, ёс зүйн талаар судалгааг 2015 оноос эхлэн авч байна. Харин магистрын түвшинд багш нарын чадамжийн талаар судалгааг авахаар төлөвлөн ажиллаж байна.
- 2016-2017 оны хичээлийн жилээс эхлэн магистр оюутнуудаас сургалтын чанарыг сайжруулах зорилгоор санал асуулга авч ажиллаж байна. /х.124/
- БОХУ хөтөлбөрийн цөм агуулгыг ахлагч бэлтгэн хэлэлцүүлж, багш нар түүнтэй уялдуулан сургалтын материалаа боловсруулсан.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн багш нар харилцан бие биенийхээ хичээлд сууж зөвлөгөө өгөх, туршлага судлах тал дутагдалтай.

Зөвлөмж:

- Багшийн сурган арга зүйн талаар хөгжүүлэх чиглэлийг тодорхой болгож, дэмжлэг үзүүлж, нөхцөл бололцоогоор ханган ажиллах.

5-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 6. Сургалтын үйл ажиллагаа

Сургалтын үйл ажиллагаа нь сургуулийн эрхэм зорилгод нийцэж, хөтөлбөрийн үр дүнд чиглэсэн, цогц чадамжид суурилсан, агуулга, арга зүй нь тасралтгүй хөгжин сайжирдаг байна.

6.1.Хөтөлбөрийн сургалтын агуулга, түүний шинэчлэл

Сургалтын агуулга нь суралцагчийн эзэмших цогц чадамжийг олгоход чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Оролцогч болон сонирхогч талуудын эрэлт хэрэгцээ ба агуулгын харьцуулсан шинжилгээ
- Сургалтын агуулга нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцсэн байдал
- Суралцагч хичээл, багшийг сонгон суралцдаг байдал чиглэсэн, онол практикийн зохистой харьцаатай, давхардалгүй, харилцан уялдаатай, сонгох боломжтой, тасралтгүй хөгждөг байна.
- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдал
- Үйлдвэрлэл, практик, клиник сургалтын агуулгыг хамтран хэрэгжүүлдэг байдал
- Зайны болон цахим хичээлүүдийг E- контент түвшинд боловсруулан сургалтад ашигласан байдал
- Хичээл хоорондын уялдаа, залгамж холбоог хангасан байдал

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Магистрын төгсөгчдөөс ажиллаж байгаа албан байгууллагуудынх нь ажил олгогчдын төлөөлөл болох 12 хүнээс санал авч фокус ярилцлага хийж, сургалтын төлөвлөгөөг 4 удаа өөрчлөн сайжруулсан.
- Тогтвортой хөгжлийн талаар дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байгаа ногоон эдийн засагт суурилсан ногоон хөгжил үзэл баримтлал, тунхаглалын үзэл санааг иш үндэс болгон мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлыг суралцагчдад олгоход чиглэжээ.
- Магистрантууд өөрийн орон нутаг, эрхэлж буй ажлынхаа онцлог, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх үүднээс хичээл судлагдахуун болон заах багшийг сонгон суралцах боломжийг тодорхой хэмжээгээр бүрдүүлжээ.
- Онол, дадлагын хичээлийн харьцааг магистр, докторын сургалтын журамд заасны дагуу шийдвэрлэдэг.
- Зарим багш нар сургалтын стандартад заагаагүй даалгавар оюутанд өгөх, орчуулга хийлгэх, юм шивүүлэх, өөрсдийн үзэл бодлоо тулгах зэрэг зөрчилтэй асуудлыг илрүүлж, үүнийг засаж залруулах талаар багш нарт шаардлага тавьж ажилладаг нь зүйтэй байна.
- БОХУ хөтөлбөрөөр 54 суралцагч төгссөнөөс 40 гаруй нь байгаль орчны үнэлгээ, хяналтын чиглэлээр судалгааны ажил туурвижээ.
- БОХУ хөтөлбөрөөр үйлчилгээ үзүүлдэг багш нарын 20 орчим хувь нь заадаг хичээлийнхээ иж бүрдлийг онлайн хэлбэрээр ELIDEMY программд оруулсан нь түүнийг магистрантууд зайнаас судлах боломжийг бий болгосон байна. БОХУ хөтөлбөрийн хорооноос 2019 онд хийх ажлын төлөвлөгөөндөө багш нарын хичээлийн иж бүрдлийг 2019 оны 06 сар хүртэл 100% онлайн хэлбэрт оруулахаар төлөвлөгөө гарган ажиллаж байна.
- ХААИС-ийн ногоон хөгжил дижитал студийг БОХУ хөтөлбөрийн ахлагч хариуцан ажиллаж байгаа бөгөөд БОХУ хөтөлбөрийн бакалаврын түвшний бүх хичээл, АЭС-ийн бакалаврын 179 хичээлийн 1-2 минутын видео танилцуулгыг бэлтгэн веб сайтад байршуулсан нь уг хөтөлбөрийн хувьд томоохон сурталчилгаа болжээ.
- БОХУ хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа, хөтөлбөрийн цөм агуулгыг хэрхэн хангаж байгааг матрицаар харуулжээ. /139-р талд/

Анхаарах асуудал:

- Хөтөлбөр дэх хичээлийн хэлбэр, онол, практикийн зохистой харьцааг хангасан байдлын тухайд тодорхой мэдээлэл тайланд дутмаг байна. “Онол, дадлагын хичээлийн харьцааг сургалтын журамд заасны дагуу шийдвэрлэдэг боловч

хичээл заадаг багш нарын мэргэжлийн ур чадвараас хамааран өөрсдийн түвшинд шийдвэрлэдэг” /134-р талд/ гэсэн нь журмын заалт нь бодит амьдрал дээр хэрэгждэггүй буюу баримталдаггүй гэсэн утга санааг илэрхийлж байна.

- Өөрийн үнэлгээний тайланд БОХУ хөтөлбөрийн хичээл хоорондын уялдаа холбоог матрицаар илэрхийлсэн боловч энэ нь тухайн багц хөтөлбөрийн бүтэц болон тухайн мэргэжлийн хичээлүүдийн дотоод агуулгад тодорхой тусгагдаагүй байна.
- Гадаадын жишиг сургуультай өөрийн хөтөлбөрийг харьцуулсан байгаа /141-144/ боловч уг харьцуулалтаар ямар дүн шинжилгээ хийж, цаашид хөтөлбөрийн шинэчлэлд юуг тусган хэрэгжүүлэх саналтай байгаа эсэх нь тодорхой бус байна.

Зөвлөмж:

- Агроэкологийн эрдмийн зөвлөлөөр БОХУ хөтөлбөрийн ахисан шатны магистрант, докторантын судалгааны ажлыг хэлэлцэхэд мэргэжил, чиглэл таарахгүй байгаагаас зарим хүндрэл бэрхшээл гарч байгаа гэх асуудлыг /тайлангийн 135-р талд/ ХААИС-ийн удирдлагууд, удирдах зөвлөл анхааралдаа авч, зохих ёсоор шийдвэрлэх нь зүйтэй.

6.2 Сургалтын арга зүй

Сургалтын арга зүй нь хөтөлбөрийн зорилгод нийцсэн, цогц чадамжид суурилсан, суралцагч төвтэй, мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи ашигладаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Сургалтын арга зүйг боловсруулсан баримт бичиг, загвар
- Сургалтад ашиглаж буй арга зүй нь мэдлэг бүтээлгэж, хэрэглэж сургахад чиглэсэн байдал
- Сургалтад хэрэглэж буй мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт технологи, программ хангамж, техник хэрэгслийн ашиглалтын судалгаа
- Сургалтын арга зүйн судалгаа, дүгнэлт, хөгжүүлдэг байдал

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БСШУЯ-ны сайдын 2014 оны А/370 тоот тушаалаар батлагдсан “Магистр, докторын сургалт явуулах нийтлэг журам”-ыг баримтлан, сургалтын арга зүйгээ боловсруулсан.
- Үр дүнд суурилсан хөтөлбөрийн үзэл баримтлалаар кейсд суурилсан сургалт /case-based learning/, асуудалд суурилсан сургалт /problem-based learning/, зориулагдсан орчинд суурилсан сургалт /studio-based learning/, туршилтад

суурилсан сургалт /experiential learning/ гэх зэрэг идэвхтэй сургалтын аргуудыг хэрэглэдэг.

- БОХУ магистрын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд ХААИС-ийн АЭС, МААБТС, МЭС-ийн Агроэкологийн сургуулийн лабораториудыг сургалтын үйл ажиллагаандаа ашигладаг.
- Мэргэжлийн лабораториудын сургалт, судалгааны шаардлагад нийцсэн эсэх талаар ХААИС-ийн СБЗА-аас ХААИС-ийн төгсөгчдөөс 2011-2015 онд лабораторийн тоног төхөөрөмжийн судалгаа, 2014 онд сэтгэл ханамжийн судалгаа авчээ.
- Улирлын төгсгөлд багш нарын сургалтын арга зүй, мэдлэг, чадвар шаардлага хангаж байгаа эсэх талаар оюутны сэтгэл ханамжийн судалгааг авч дүгнэдэг.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдөөс багш нарын мэдлэг, ур чадвар, заах аргад өгсөн үнэлгээний судалгаанаас харахад багш нарын заах арга, ур чадварыг сайжруулах шаардлага байгааг анхаарч ажиллах.

Зөвлөмж:

- Багш нарын заах арга зүйг сайжруулах талаар дотоод, гадаадын багш бэлтгэх их, дээд сургууль, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Нийслэлийн боловсролын газар зэрэг холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх нь сургалтын чанарыг сайжруулахад дөхөмтэй.

6.3. Суралцагчийн үнэлгээ

Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг бүрэн дүүрэн, үнэлдэг арга зүйтэй, түүнийг байнга сайжруулдаг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Мэдлэг, ур чадвар, хандлагын түвшин тогтоох, ахиц дэвшлийг үнэлэх үнэлгээний арга, аргачлал, хэрэглээ
- Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл нэг бүрийн үнэлгээний арга, хэлбэр нь суралцагчдыг тасралтгүй хөгжихөд хөтөлдөг байдал
- Суралцагчийн үнэлгээ нь ил тод, найдвартай, шударга, ижил тэгш зарчмыг хангасан байдал
- Суралцагчийн гаргаж буй амжилтууд

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БОХУ хөтөлбөрөөр суралцагсдын мэдлэг, чадварыг үнэлэхдээ холбогдох эрх зүйн актуудыг баримтлахаас гадна БОХУ хөтөлбөрийн хороогоор суралцагч бүрийн судалгааны арга зүйг хэлэлцэж, зөвлөн чиглүүлдэг.
- АЭС-ийн Экологийн тэнхимийн хурлаар магистрын арга зүйг хэлэлцэн баталдаг жрумыг баримтлан ажилладаг.
- Магистрант судалгааны ажлын үр дүнгээрээ 2-оос доошгүй эрдэм шинжилгээний өгүүлэл туурвиж байж магистрын ажил хамгаалах эрх үүсдэг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрийн хүрэх үр дүн болон хичээл бүрээр оюутны эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг хэрхэн үнэлж дүгнэж байгаа арга, аргачлал нь хэр оновчтой, бүтээлч байгаа эсэхэд дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийн зорилго, үр дүнг бодитой илрүүлэх үнэлгээний механизмыг бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй.

Зөвлөмж:

- Оюутан суралцагсдыг үнэлэх үнэлгээ нь эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг илрүүлэхээс гадна суралцагчийн цаашид тасралтгүй хөгжихөд нь хөтөлдөг арга хэрэгсэл байх нөхцөлийг бүрдүүлэх

6-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 7. Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө

Хөтөлбөрийн үр дүн нь сургуулийн эрхэм зорилго, зорилтыг хангаж, сонирхогч талуудын эрэлтэд нийцсэн, үнэ цэнэтэй байна.

7.1. Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрөөр төгсөгч нь сонирхогч талуудын эрэлт хэрэгцээг хангасан, улс орны болон салбарын ирээдүйн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулан сэтгэл ханамжтай ажиллаж, амьдрах цогц чадамжтай байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Төгсөгчдийн ажил эрхлэлтийн судалгаа, ажлын байрны нийцлийн судалгааг тогтмол явуулж, хөтөлбөрийн шинэчлэлд тусгаж хэрэгжүүлдэг байдал
- Төгсөгчид, ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаа
- Төгсөгчид ажлын байраар хангагдах хүртлээ хүлээхэд зарцуулах дундаж хугацаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2018 оноос эхлэн БОХУ хөтөлбөрийн магистрын төгсөгчдийн ажил эрхлэлт, мэдлэг ур чадвар ажлын байрны шаардлагад нийцэж байгаа талаар ажил олгогчдын судалгааг авахаар төлөвлөсөн байна .
- 2017 онд төгсөгчдөд зориулсан мэргэжил дээшлүүлэх сургалтыг зохион байгуулж, нийт 65 мэргэжилтэн хамрагдаж, тэдгээрээс хөтөлбөрийг сайжруулах талаар санал солилцох үйл ажиллагаа явуулжээ.
- Төгсөгчдийн сэтгэл ханамжийн судалгаагаар 92 хувь мэргэжлээрээ ажиллаж байгаа, мэргэжилдээ хэр сэтгэл хангалуун байгааг судалж үзэхэд санал асуулгад оролцсон төгсөгчдийн 90 хувь нь сэтгэл хангалуун, 10 хувь нь тааруу гэсэн байна. /х.163/
- БОХУ хөтөлбөрөөр төгссөн 54 магистр оюутнаас суралцаж буй хугацаандаа ажил эрхлээгүй 35 оюутан байсан бөгөөд тэд төгсөөд 6 сарын дараа ажилд орсон байна. Иймд ажилд ороход зарцуулах хугацаа 1-6 сар байна.

Анхаарах асуудал:

- Төгсөгчдийн ажлын байрны судалгааг хийсэн боловч үүний үр дүнд ямар арга хэмжээ авч ажиллах нь тодорхой бус байна.

Зөвлөмж:

- Мэргэжил дээшлүүлэх сургалтуудыг хэрэгцээн дээр тулгуурлан тогтмол зохион байгуулах хэрэгтэй.

7.2.Хөтөлбөрийн үр нөлөө:

Хөтөлбөр үр дүнгээ үнэлүүлэх, үнэ цэнээ тодорхойлох, ахиц дэвшлээ харуулах нотолгоотой байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрөөр төгсөгчдийн амжилтууд
- Салбар, хөдөлмөрийн зах зээлд эзлэх байр суурь
- Мэргэжлийн салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр /Төрийн болон ТББ-ын зүгээс хийсэн үнэлгээ, судалгаа/

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- БОХУ хөтөлбөр бол Монголын байгаль орчны тогтвортой байдлыг хангахад маш чухал хөтөлбөр бөгөөд төгсөгчид МУ–ын хөгжил бүтээн байгуулалтанд хувь нэмрээ оруулан ажиллаж байна./х.164/
- Ажил олгогчдын сэтгэл ханамжийн судалгаагаар төгсөгчдийг дараах байдлаар үнэлсэн байна:
 - Энэ хөтөлбөрөөр төгсөгчид эрх зүйн хяналтыг сайн мэддэг
 - Эдийн засгийн тооцооллыг бусад сургуулийн төгсөгчдөөс илүү хийдэг
 - Ургамлын нөхөн сэргээлтийг сайн хийдэг

- Зураглалын программ дээр сайн ажилладаг
- Байгаль орчны үнэлгээний аргачлал сайн эзэмшсэн байдаг
- БОХУ магистрын хөтөлбөр нь бусад МУИС, ШУТИС болон бусад хөтөлбөрөөс ялгаатай нь байгаль орчны үнэлгээ, хяналтыг болон инженер технологийн шийдлийг онцгойлон үздэг учраас төгсөгчид 100% ажлын байртай.
- БОХУ магистрын хөтөлбөрөөс санаачлан, жил бүр байгаль хамгаалах технологи, байгаль орчин ба эрх зүй, байгаль орчны хяналт гэсэн чиглэлүүдээр сургалт семинар зохион байгуулж, байгаль орчны болон хууль, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудтай хамтран ажиллаж байна.
- 2012 оны шинэчлэн батлагдсан байгаль орчны багц хуулийн байгаль орчныг хамгаалах хуулинд байгаль орчны хяналт хийдэг байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нь энэ чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн мэргэжилтэн байна гэдэг заалтыг оруулж өгч хууль санаачлагч багтай хамтран ажилласан.

Анхаарах асуудал:

- Технологийн шийдлийг зөвлөмжлөх талаар хичээлүүдийг сургалтын төлөвлөгөөндөө тусгах
- Инженерийн тооцоолол, туршилт судалгаатай хичээлийг нэмэгдүүлэх
- Сэргээгдэх эрчим хүчийг ашиглах технологийн асуудлыг тусгах
- Судалгааны үр дүнгээр математик боловсруулалт хийх

Зөвлөмж:

- Байгаль орчны чиглэлээр гадаадын хөрөнгө оруулалтай төсөл дээр ажиллах, гадаадад мэргэжил дээшлүүлэх шаардлага ихээхэн байдаг учир төгсөгчдийн мэргэжлийн англи хэлний мэдлэгийг сайжруулах талаар хөтөлбөрт тусгаж өгөх хэрэгтэй.

7.3. Үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх

Үндэсний болон олон улсын хэмжээнд хөндлөнгийн үнэлгээ, магадлан итгэмжлэл хийлгэн суралцагчдын цогц чадамжийг хүлээн зөвшөөрүүлж, олон улсын түвшинд суралцах боломжийг нэмэгдүүлдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Суралцаж буй гадаад оюутны тоо
- Олон улсын хамтарсан хөтөлбөрийн хэрэгжил
- Улсын болон олон улсын чанартай олимпиад, уралдаан тэмцээнд үзүүлсэн амжилт
- Олон улсад магадлан итгэмжлэгдсэн дараагийн шатны хөтөлбөрт үргэлжлүүлэн суралцаж буй төгсөгчдийн хувь

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- 2017 оны 06 сарын 29-ний өдрийн А/52 БСШУ-ны сайдын тушаалаар Байгаль ашиглалт хяналт үнэлгээ 07120103 гэсэн бие даасан хөтөлбөр баталснаар БОХУ хөтөлбөр БОХТ хөтөлбөрөөс бие даан хөгжих эрх зүйн үндэс тавигдсан.
- БОХТ үндэсний магадлан итгэмжлэлээр орж 5 жилийн хугацаатай бакалаврын хөтөлбөрөө магадлан итгэмжлүүлсэн байна.
- 2016-2017 оны хичээлийн жилд 1 гадаад оюутан суралцсан байна.
- БОХУ хөтөлбөрийн 2 төгсөгч гадаадын их сургуульд докторантурт суралцаж байна.

Анхаарах асуудал:

- Олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө байхгүй байна.

Зөвлөмж:

Хөтөлбөрийн багш нарын нөөц бололцоог ашиглан, олон улсад хүлээн зөвшөөрөгдөх хөндлөнгийн үнэлгээ хийлгэх талаар урт болон богино хугацааны төлөвлөгөө гарган ажиллах боломж байна.

7.4. Хөтөлбөрийн нээлттэй, ил тод байдал

Хөтөлбөр хэрэгжүүлэгч нэгж нь өөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллийг түгээдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтийг үнэн зөв, ил тод, дэлгэрэнгүй, сүүлийн үеийн мэдээллээр тогтмол хангадаг байдал
- Веб сайтын мэдээллийн иж бүрэн байдал, тогтмол ажиллагаа

Шалгуурыг хангасан байдал: Бүрэн хангасан

Онцлог зүйл/Туршлага:

- Хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар ажлын тайланг жил бүр МДС-д тайлагнадаг.
- Сургуулийн цахим хуудас байнгын, тасралтгүй ажиллагаатай.
- ХААИС-ийн Дижитал студийг тухайн хөтөлбөрийн багш хариуцан ажиллуулдаг бөгөөд бакалаврын түвшний 29 хөтөлбөрийн танилцуулгыг хийж сургуулийн веб хуудсанд байршуулснаар хөтөлбөрт элсэгчдийн тоо нэмэгдсэн байна.

Анхаарах асуудал:

- Магистрын хөтөлбөрийн үйл ажиллагааны талаар олон нийтэд тогтмол хүргэдэг байдал дутагдалтай

Зөвлөмж:

- Магистрын хичээлүүдийг цахим хэлбэрээр явуулах талаар анхаарч ажиллах хэрэгтэй.

7-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Бүрэн хангасан

Шалгуур 8. Чанарын үнэлгээ, баталгаажилт

Хөтөлбөрийг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэгдсэн дотоод чанарын баталгаажуулалтын механизмтай, хөндлөнгөөс үнэлүүлдэг байна.

8.1. Хөтөлбөрийн хяналт, шинжилгээ, үнэлгээг тогтмол, давтамжтай хийдэг байна.

Үзүүлэлт нотолгоо:

- Хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуултыг хангах удирдлага, зохион байгуулалтын шийдэл, үр дүн
- Дотоод чанарын баталгаажуулалтын тогтсон бодлого, хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, үнэлгээ
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоо
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрч чадсан эсэхийг мэдээ баримтад тулгуурлан дүгнэж өөрийн үнэлгээг хийдэг байдал
- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг хөтөлбөрийн ахиц, дэвшилд системтэйгээр ашигласан байдал
- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг хянасан байдал
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд эргэх холбоо үүсгэх

Шалгуурыг хангасан байдал: Хэсэгчлэн хангасан

Онцлог зүйл / Туршлага:

- ХААИС–ийн хяналт, шинжилгээ, үнэлгээ нь стратегийн төлөвлөлт, стратегийн үйл ажиллагааны хэрэгжилт болон үр дүнгийн хяналт үнэлгээ гэсэн 3 үе шаттай хийгдэнэ.
- ХААИС хэмжээнд захиргааны албанд дотоод аудит 1, хяналт шинжилгээний мэргэжилтэн 1, хяналт шинжилгээ, чанар хариуцсан мэргэжилтэн 1 нийт 3 хүн бүхий дотоод, аудит, мониторингийн албатай. Дотоод чанарын алба нь багш нарын ажил, сургалтын чанарт хяналт тавьдаг.

- Мөн хөтөлбөрийн Ерөнхий хороо, дэд хороо болон бүрэлдэхүүн сургуулийн хороо түүнчлэн тэнхимийн буюу мэргэжлийн хөтөлбөрийн хороонууд хөтөлбөрийн дотоод чанарын баталгаажуулалт хийдэг.
- ХААИС нь “Дээд боловсролын шинэчлэл”-ийн хүрээнд дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоо бий болгох зорилт тавьсан энэ хүрээнд ХААИС-ийн чанарын баталгаажуулалтын журам боловсруулсан.
- Хөтөлбөр төлөвлөсөн үр дүндээ хүрсэн эсэхийг үнэлэхдээ төгсөгчдийн мэргэжлээрээ ажиллаж байгаа хувь, ажил олгогч, төгсөгчийн сэтгэл ханамжийн хувь гэсэн үзүүлэлтээр хэмждэг. Оролцогч талуудын судалгааны үр дүнд дүн шинжилгээ хийж, багшийн заах арга зүйг сайжруулахад анхаарал хандуулж ажилдаг.

Анхаарах асуудал:

- Хөтөлбөрт орсон өөрчлөлтүүдийн үр нөлөөг мөшгиж хянасан байдал хангалтгүй.
- Дотоод чанарын баталгаажуулалтад хөтөлбөрийн оролцогч болон сонирхогч талуудын оролцоог хангахад чиглэсэн судалгааг БОХУ хөтөлбөрийн хүрээнд хийх.
- Шат шатны хөтөлбөрийн хороонууд үйл ажиллагааны уялдаагаа сайжруулж хөтөлбөрийг шинэлэх хүрээнд хийгдэх хичээлийн төлөвлөлтийг их сургуулийн болон хөтөлбөрийн зорилго, зорилтод нийцүүлэх

Зөвлөмж:

- Хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах зорилгоор хийсэн судалгааны үр дүнд үндэслэн гарсан чанарыг сайжруулах үйл ажиллагааг холбогдох төлөвлөгөөнд тусгах эсвэл бие даасан төлөвлөгөө гаргаж хэвших
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд эргэх холбоог сайжруулахын тулд төгсөгчдийн мэргэжлийн холбоог бий болгож, тэдэнд ажлын байранд гараад шаардагдаж буй ур чадварыг тандах
- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нэгжийн чанарын баталгаажилтын талаарх мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх

8-р шалгуурын талаарх шинжээчийн эцсийн үнэлгээ: Хэсэгчлэн хангасан

ДҮГНЭЛТ:

Шалгуур		Бүрэн хангасан (2)	Хэсэгчлэн хангасан (1)	Хангааг үй (0)	Үндэслэл, шалтгаан
1	Хөтөлбөрийн төлөвлөлт	2			3 дэд шалгуураас БҮРЭН ХАНГАСАН-3

2	Хөтөлбөр хэрэгжүүлэх орчин, технологийн нөхцөл	2			3 дэд шалгуураас БҮРЭН ХАНГАСАН-3
3	Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	2			6 дэд шалгуураас БҮРЭН ХАНГАСАН-5, ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН-1
4	Суралцагчид чиглэсэн үйл ажиллагаа	2			5 дэд шалгуураас БҮРЭН ХАНГАСАН-4, ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН-1
5	Багшийн үйл ажиллагаа	2			4 дэд шалгуураас БҮРЭН ХАНГАСАН-4
6	Сургалтын үйл ажиллагаа	2			3 дэд шалгуураас БҮРЭН ХАНГАСАН-2, ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН-1
7	Хөтөлбөрийн үр дүн, үр нөлөө	2			4 дэд шалгуураас БҮРЭН ХАНГАСАН-4
8	Чанарын үнэлгээ, баталгаажуулалт		1		1 дэд шалгуураас ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН-1
Дүгнэлт		Нийт 29 дэд шалгуураас БҮРЭН ХАНГАСАН нь 25, ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН нь 4 буюу нийт 8 үндсэн шалгуурын 7 нь “БҮРЭН ХАНГАСАН”, 1 “ХЭСЭГЧЛЭН ХАНГАСАН” үнэлгээтэй дүгнэгдлээ.			

ШИНЖЭЭЧИЙН БАГИЙН ЭЦСИЙН ДҮГНЭЛТ:

Баримт материал, нотлох баримт, уулзалт ярилцлага дээр үндэслэн шинжээчийн баг ХААИС-ийн Магистр, докторын сургуулийн “Байгаль орчны хяналт үнэлгээ” магистрын сургалтын хөтөлбөрийг БМИҮЗ-ийн сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ерөнхий шалгуур шаардлагад нийцэж байгаа тул “Шалгуурыг бүрэн хангасан” гэж дүгнэж байна. Шинжээчийн багийн дүгнэлтийг Инженерчлэл, үйлдвэрлэл, зохион бүтээлт чиглэлээр хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлд хүргүүлж байна.

Шинжээчийн багийн ахлагчийн нэр, гарын үсэг/Ц.Дэлгэрсайхан/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../З.Баттогтох/

Шинжээчийн багийн гишүүний нэр, гарын үсэг...../Д.Сэржмядаг/

V. Оролцогчдын нэрс

I. Ярилцлагад оролцсон багш нарын нэрс.

№	Багшийн нэр	Албан тушаалын зэрэглэл	Ажилл асан жил	Заадаг хичээл	Утасны дугаар
1	Ж.Ундармаа Р.Чанцалдулам	Профессор Доктор (Ph.D)	35	Судалгааны ажлын төлөвлөлт, бүтээл бичих арга	99050690
2 3	Т.Оюунчимэг Ц.Банзрагч	Профессор Доктор (Ph.D)	31	Байгаль орчны үнэлгээ, аудит Ландшафтын экологи Байгаль орчны эрх зүй Байгаль орчны ЭЭЗҮ	99031969
4	Ш.Оюунтуяа	Дэд профессор	23	Агаарын бохирдол, үнэлгээ Эрсдлийн үнэлгээ	99787358
5	Д.Ундармаа	Дэд профессор	24	Ургамал хамгаалах цогц аргын менежмент	99108034
6	Д.Түвшинбаяр	Дэд профессор	23	ГМС-ийн орон зайн шинжилгээ	99996904
7	Х.Баярмаа	Дэд профессор	25	Агроэкологи	88092051
8	О.Нямсүрэн	Дэд профессор	15	Газрын кадастрын үнэлгээ	99094698
9	Г.Амарсанаа	Дэд профессор	20	Хөрсний үржил шимийн нөхөн үйлдвэрлэл	99256773
10	П.Хорлоо	Доктор (Ph.D)	19	Байгаль шинжлэлийн судалгааны арга зүй ХБО-ны микробиологи	99017582
11 12	Т.Байгал-Амар О.Бүрэнжаргал	Доктор (Ph.D) Доктор (Ph.D)	22 16	ХБО-ны экологи	80540714 88066085
13	А.Энхтөр	Доктор (Ph.D)	34	Дүйцүүлэн хамгаалал	91116882
14	Д.Цэрэндорж	Доктор (Ph.D)	35	Уул уурхайн ашиглалтын технолог	
15	З.Баттогтох	Доктор (Ph.D)	32	Хог хаягдлын менежмент	99031969
16	Т.Байгаламар Г.Долгорсүрэн	Доктор (Ph.D) Доктор (Ph.D)	22 35	Усны нөөцийн менежмент	80540714 99140265
17	М.Хишигжаргал Т.Байгаламар	Доктор (Ph.D) Доктор (Ph.D)	18 22	Байгаль шинжлэлийн судалгааны арга зүй	99159152 80540714

II. Оюутны нэр

№	Нэр	Элссэн он	Утас	Ажлын хаяг
1	Б.Оргилмаа	2018	88102565	/Өмнөговь аймгийн БОАЖГ-ын ахлах мэргэжилтэн
2	Т.Дашцэдэн/	2017	88329932	ГСА-ийн БОАЖГ-ын мэргэжилтэн
3	Б.Жаргалцэцэг/	2018	99234708	Цэнгэг усны нөөцийн газрын БО-ны мэргэжилтэн
4	Г.Алтанцэцэг/	2018	86087725	Сайхан Ариун Дэлхий ХХК-ийн мэргэжилтэн
5	Ө.Алтанцэцэг	2017	88068846	Байгаль орчны үнэлгээний компани мэргэжилтэн
6	Р.Айсауле/	2017	99423461	Байгаль орчны үнэлгээний байгууллагад шинжээч
7	Т.Саранчимэг	2018	90101120	Дундговь аймгийн МХГ-ын БОХУАБ
8	Б.Түмэнод	2016	88124956	Говь ХК-ийн байгаль орчны мэргэжилтэн
9	Б.Ганбаяр	2018	99129162	Төв аймгийн БОХУБ
10	Н.Тэгшжаргал	2017	88084429	СБД-ийн газрын албанд мэргэжилтэн

III. Ажил олгогч

№	Нэр	Утас	Ажлын хаяг
1	Ц.Банзрагч доктор /Байгаль орчны гавьяат ажилтан	91115345	Олон улсын төслийн зөвлөх
2	Г.Нямдаваа профессор /Байгаль орчны гавьяат ажилтан	99829668	БОАЖЯ ХБОБНУГ-ын дарга
3	Ю.Дэлгэрмаа /доктор	91910052	БО-ны аудитын компани захирал
4	С.Энхамгалан/доктор	99008154	ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн ЭША
5	Б.Гантулга магистр	88038485	Дундговь аймгийн БОАЖГ-ын дарга
6	Р.Пүрэвтулга	88080552	/Өмнөговь аймгийн БОАЖГ-ын дарга
7	Л. Өлзийбаяр магистр	99086190	Байгаль орчны мэргэжлийн байгууллагын захирал
8	Т.Ундрахэрдэм	99904046	Уул уурхайн компани
9	Н.Эрдэнэцогт	93037698	Сэлэнгэ аймгийн МХГ-ын ГУУБОХ-н хэлсийн дарга
10	П.Буянхишиг	80094864	АХХҮХ ерөнхий нарийн бичгийн дарга
11	Б.:Мөнхсайхан/	99811042	НБОГ-ын ахлах мэргэжилтэн
12	Б.Батзаяа	96960600	/БОАЖЯ-хэлтсийн дарга

IV. Төгсөгчид

№	Нэр	Утас	Төгссөн он	Ажлын хаяг
1	Т.Жигмэдсэрчин	99068125	2017	Кожеговь ХХК-ийн мэргэжилтэн
2	Б.Батманлай	88058250	2017	Кожеговь ХХК-ийн мэргэжилтэн
3	С.Энхбилэг	99171434	2017	Олон улсын төсөлд зохицуулагч
4	Д.Догсом	99012847	2013	Орхоны хөндийн ТХГН-ийн мэргэжилтэн
5	Т.Төмөрцож	88012456	2012	УШУОШТөвд эрдэм шинжилгээний ажилтан
6	З.Цэцэгмаа	91010016	2018	Өвөрхангай Хужирт сумын БОУАБ
7	Б.Лхагвасүрэн	91031906	2016	Мэдээлэл технологийн үндэсний паркийн мэргэжилтэн
8	С.Уранзаяа	99195692	2016	хувийн сектор

**ХААИС-ийн Магистр, докторын сургуулийн “Байгаль орчны хяналт үнэлгээ”
бакалаврын сургалтын хөтөлбөр дээр ажиллах шинжээчдийн ажлын хуваарь
2019 оны 2 дугаар сарын 22, 23**

Хугацаа	Үйл ажиллагаа	Хариуцах эзэн
2019-02-27	Лхагва гараг	
	Зохицуулагч шинжээчийн багийг танилцуулна	Зохицуулагч
	Шинжээчийн багийн ахлагч үг хэлнэ: - Магадлан итгэмжлэлийн үйл явц, хуваарийг танилцуулах	Шинжээчийн багийн ахлагч
	Сургуулийн захирал үг хэлнэ	Өөрийн үнэлгээний багийн ахлагч
	Удирдлага болон ӨҮ-гийн багтай уулзах: - Удирдлагын бэлдсэн хөтөлбөрийн товч танилцуулга	Шинжээчийн багийн ахлагч
10:00-12:00	Сургуулийн бэлтгэсэн материал, илрэл нотолгоотой шинжээчид танилцана	Шинжээчид
12:00-13:00	Сургуультай танилцах аялал	Шинжээчид
13:00-14:00	Өдрийн хоол	
14:00-16:00	Оюутнуудтай хийх уулзалт	Шинжээчид
	Багш нартай хийх уулзалт	Шинжээчид
16:00-17:00	Шинжээчид номын сан болон лаборатори, үйлчилгээний хэсэгтэй танилцана	Шинжээчид
17:00-18:00	Өөрийн үнэлгээний тайлангийн нотлох баримттай танилцах	Шинжээчид
2019-02- 28	Пүрэв гараг	
09:00-10:00	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	Шинжээчид
10:15-11:15	Төгсөгчидтэй хийх уулзалт	
11:30-12:30	Ажил олгогчидтой хийх уулзалт	
12:30-13:30	Өдрийн хоол	
13:30-14:30	Тайлантай холбоотой нотлох баримттай танилцах, холбогдох хүмүүсээс тодруулга, лавлагаа авах	
14:30-17:00	Шинжээчид дүгнэлтээ хэлэлцэн, гаргана. Нэмэлт материал үзэх танилцах /Бүрэн хангасан, хэсэгчлэн хангасан, хангаагүй/	
17:00-18:00	Шинжээчдийн баг магадлан итгэмжлэлийн эцсийн шийдвэрийг бус, урьдчилсан дүгнэлтийг байгууллагад мэдэгдэнэ.	

VI. Хөтөлбөрийн өөрийн үнэлгээний багаас ирсэн санал
/албан бичгийг оруулах/